



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10.00 цагт Төрийн нарийн бичгийн даргын хуралдааны танхимд боллоо.

Ёслолын ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Гантогтох, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Батмөнх, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Отгонцэцэг, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Малын генетик, нөөцийн хэлтсийн дарга Д.Батсүрэн нар оролцлоо.



Төрийн захиргааны албан хаагчаар томилогдсон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Ё.Мөнхтуяа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн Н.Одончимэг, мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ нар **“Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ”** хэмээн Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөлөө.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ